

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ,  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ТУС  
ТУС БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ УХНЫН АЛТАНХҮҮГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## **1.Хүний хөгжлийн бодлого:**

### **1.1 Боловсролын талаар:**

1.1.1 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ.

1.1.2 Цэцэрлэг сургуулийн багшлах боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэнэ.

1.1.3 Багш нарыг хөгжүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын үр дүн ур чадварыг гол шалгуур болгон шалгаруулдаг урамшуулалын тогтолцоог сайжруулна.

1.1.4 Онцгой амжилт гаргасан суралцагчдын дэмжих, урамшуулах санг байгуулж, хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож ажиллана.

1.1.5 Сургалтын байгууллагуудын орчин нөхцөл, өрсөлдөх чадавхийг сайжруулах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

### **1.2 Эрүүл мэндийн чиглэлээр:**

1.2.1 Орон нутгийн онцлогтой өвчлөлийн судалгааг нарийвчлан судалгааг гаргаж, түүнтэй тэмцэх бууруулах стратеги , хөтөлбөрийг боловсруулж ажиллана.

1.2.2 Хөдөлгөөний хомсдол, дэлгэцийн донтолт, архидалт зэрэг нийгмийн хор хөнөөлтэй, хүүхэд залуучуудын эрүүл мэндэд асар хортой өвчлөлийн эсрэг Төрийн бус байгууллагууд, иргэд, төрийн байгууллагууд хамтран ажиллана.


1.2.3 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг урт хугацаанд төлөвлөн бусад хөтөлбөр, бодлогын бичиг баримтуудтай уялдуулан хэрэгжүүлэн ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулна.

1.2.4 Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ

### **1.3 Хандлага, нөлөөлөлийн талаар.**

1.3.1 Иргэдийн хандлагыг өөрчлөх, нийгмийн сэтгэлзүйд нөлөөлөх сургалтыг төрийн бус байгууллагуудтай хамтран хөтөлбөртэйгээр зохион байгуулж, сэтгэлгээг эерэг хандлагад чиглүүлэх

1.3.2 Орон нутгийн удирдлагын бүх түвшинд хүн төвтэй төрийн бодлого, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, олон нийтийн оролцоотой хяналтыг тавьж хэрэгжүүлнэ.



## **2.Сайн засаглалын бодлого:**

### **2.1 Хууль эрхзүйн чиглэлээр:**

2.1.1 Шийдвэр гаргах, мэдээлэл хүргэх, хяналт тавих бүхий л түвшинд иргэд, төрийн бус байгууллагын идэвхи оролцоог хангаж, түншлэлийн гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

2.1.2 Иргэдийн хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар нийгэм, цаг үедээ тохирсон шинэ сургалтын аргазүйг судлан, нэгдсэн хөтөлбөртэйгээр зохион байгуулна.

2.1.3 Иргэн төрийн эргэх холбоо, хамтын ажиллагааг чухалчилж, иргэндээ ойр, ээлтэй төрийн албан хаагч, төрийн байгууллага, төрийн удирдлага байх зарчмыг хэрэгжүүлж ажиллана.

### **2.2 Цахим засаглал**

2.2.1 Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнүүд цахим хэлбэрээр үзүүлэх нөхцлийг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.2.2 Мэдээлэл, сурталчилгааны ажлыг цахим хэлбэрт шилжүүлж, үр дүнг дээшлүүлнэ.

2.2.3 Өндөр хурдны хямд өртөгтэй, интернетийн сүлжээг суманд байгуулж, малчдыг мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.

2.2.4 Мэдээлэл технологийн ажилтнуудыг бэлтгэж, иргэдийн цахим орчинд ажиллах, аюулгүй байдлыг хамгаалахад анхаарч ажиллана.

## **3. Эдийн засгийн хөгжлийн бодлого:**

### **3.1 Хөдөө аж ахуй**


3.1.1 Малын гаралтай бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийж, зах зээлд нэмүү өртөг шингээн зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

3.1.2 Малын үүлдэр угсааг сайжруулах замаар нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлнэ.

3.1.3 Нутгийн омгоор баталгаажсан “Шил адууг” цаашид брэнд болгох, удмын санг хамгаалах талаар санаачлагатай ажиллана.

3.1.4 Бэлчээрийг ашиглах, хамгаалах, усжуулах менежментийн төлөвлөгөөтэй болж, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллага, малчидтай хамтран зохион байгуулна.

3.1.4 Малыг эрүүлжүүлэх ажлыг чанартай, хүртээмжтэй болгох замаар эрүүл бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тохирлын гэрчилгээтэй болгох, малчдын нөхөрлөлийн



үйл ажиллагааг эрчимжүүлэх, тэдний зах зээлийн нөхцөлд ажиллах мэдлэг мэдээллийг дээшлүүлнэ.

### 3.2 Хариуцлагатай уул уурхай, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар:

- 3.2.1 Стратегийн ордоос бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлэх талаар холбогдох байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.
- 3.2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, энэ хүрээнд хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэнэ.
- 3.2.3 Сумын төвийн ногоон байгууламжийг тодорхой хувиар нэмэгдүүлэхэд анхаарч, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж, төрийн болон төрийн бус байгууллага иргэдтэй хамтран ажиллана.
- 3.2.4 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллаж буй иргэд, байгууллагыг шалгаруулж урамшуулах журмыг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.
- 3.2.5 Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан, иргэдийн ажлын байр орлогыг нэмэгдүүлнэ.

### 3.3 Дэд бүтцийг сайжруулах талаар:

- 3.3.1 Сумын түүхт 100 жилийн ойг угтсан бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан иргэдээр хэлэлцүүлж, олонхын санал тусган хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.
- 3.3.2 Сумын төвийн шинэчлэл төслийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.3.3 Соёл, спортын цогцолборын барилга барих ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.3.4 Сумын төвийн ЦДАШ-ыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.3.5 Нэгдсэн халаалтын шугамыг жил бүр өргөтгөж, байнгын дулааны эх үүсвэрт холбогдсон өрх, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ.
- 3.3.6 Нийтийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж орон сууцны хороолол байгуулах ажлыг эхлүүлнэ.

